



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/120

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр “Журам батлах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтын зардалд 460,000 (дөрвөн зуун жаран мянган) төгрөг, төслийн явц үр дүнд хяналт тавих үйл ажиллагааны бичиг хэргийн зардалд 364,000 (гурван зуун жаран дөрвөн мянган) төгрөг, шатахууны зардалд 237,600 (хоёр зуун гучин долоон мянга зургаан зуун) төгрөг, шуудан холбооны зардалд 85,000 (наян таван мянган) төгрөг, программ хангамжийн зардалд 100,000 (нэг зуун мянган) төгрөг, нийт 1,246,600 (нэг сая хоёр зуун дөчин зургаан мянга зургаан зуун) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 1,246,600 (нэг сая хоёр зуун дөчин зургаан мянга зургаан зуун) төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН